



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/132

Ховд

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Буянт багийн Эко хорооллын 1 дүгээр гудамжны 5 тоотод байрлах Төмөр-Очирын Мягмардорж (пю76120577)-ийн эзэмшлийн гэр, орон сууцны зориулалттай 143 метр квадрат газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмших эрх нь сунгагдсан иргэнтэй гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Дөлбадрал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ